



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Нислэгийн журам хүчингүй болгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, ИНД-91 бүлэг Г "Ил харааны нислэгийн дүрэм", ИНД-91 бүлэг Д "Хэрэглэлийн нислэгийн дүрэм", ИНД-95 "Хэрэглэлийн нислэгийн дүрмээр буултын ойртолт үйлдэх ба сансрын навигаци ашиглах дүрэм", ИНД-175.57.(б).2/ дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны байцаагчийн 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 807/17 дугаар дүгнэлт, 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 804/17 дугаар дүгнэлтийг үндэслэн Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн "Ойртолт үйлдэх журмуудыг батлах тухай" А/207 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан Завхан аймгийн "Тосонцэнгэл" нисэх буудлын ил хараагаар ойртолт үйлдэх нислэгийн журам, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/335 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан Өмнөговь аймгийн "Таван толгой" нисэх буудалд хэрэглэлийн нислэгээр ХБЗ-15-д А,В ангиллын агаарын хөлөг буултын оролт үйлдэх нислэгийн журам, мөн тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан хэрэглэлийн нислэгээр ХБЗ-15-д С ангиллын агаарын хөлөг буултын оролт үйлдэх нислэгийн журам, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2013 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А/517 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан ХБЗ-33-д А,В ангиллын агаарын хөлөг буултын оролт үйлдэх нислэгийн журам, мөн тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан хэрэглэлийн нислэгээр ХБЗ-33-д С ангиллын агаарын хөлөг буултын оролт үйлдэх нислэгийн журмыг 2018 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны байцаагчийн 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 807/17 дугаар дүгнэлтийн дагуу Завхан аймгийн "Тосонцэнгэл" нисэх буудлын ил хараагаар ойртолт үйлдэх нислэгийн журмыг дахин боловсруулахыг Нислэгийн журам боловсруулалтын алба /Г.Түвшинбаяр/-нд үүрэг болгосугай.

3. Дээрх нислэгийн журмуудыг хүчингүй болсон талаар зарлан мэдээлэхийг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба /П.Ариунгэрэл/-нд үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Ё.Эрдэнэбат/-т үүрэг болгосугай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

Б.АЛТАНЦОМ

